



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.20 № 1/145

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг  
эрчимжүүлэх тухай

“Цэвэр агаарын сангийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”-д аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

“Нийслэлийн нийтийн тээврийн их багтаамжийн автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах” ажлын гүйцэтгэгчээр “Туртелком” ХХК шалгарч, 400 автобусанд шингэрүүлсэн шатдаг хийн нэмэлт төхөөрөмж 2011 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 2011 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хооронд нийлүүлж, суурилуулахаар гэрээ байгуулжээ.

Гэрээт хугацаа дууссанаас хойш хугацааг сунгалгүй явсаар 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт гэрээ хийж 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгажээ.

Өнөөдрийн байдлаар Туртелком ХХК нь 2013 оны 7 дугаар сарын байдлаар 3,042 сая төгрөгийн санхүүжилт авч Автобус-1, Автобус-3, Цахилгаан тээвэр компанийн нийт 250 автобусанд уг төхөөрөмжийг суурилуулсан байна.


Гэрээт хугацааг сунгаснаас хойш 9 сар өнгөрөхөд ажлын гүйцэтгэл 63 хувьтай, гэрээ дуусахад 12 хоног хугацаа үлдэж энэ ажлын явц удаашралтай байгаа нь:

- Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 7 хувийн хэвшлийн компаниуд 150 их багтаамжийн автобусаа чөлөөлж өгөөгүй
- Дашваанжил компанийн Автомашин хийгээр цэнэглэх станцууд бүрэн ашиглалтанд ороогүй шалтгаантай байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн төсөл, арга хэмжээний ажлын зохион байгуулалт, гүйцэтгэлийг сайжруулах, Нийслэлийн тээврийн газартай хамтран үлдэгдэл 150 их багтаамжийн автобусанд суурилуулах арга хэмжээг яаралтай авч, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллан, 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг шаардаж байна. Энэхүү шаардлагын биелэлтийг гаргахыг Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяа, Нийслэлийн тээврийн газрын дарга Ч.Энхбат, Цэвэр агаарын сангийн Гүйцэтгэх захирал Д.Баасан, “Туртелком” ХХК-ийн Ерөнхий захирал С.Мөнхжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АУДИТОР



Э.УЯНГА